19.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 88 хувиас, 2017 оны төсвийн жилд 85 хувиас, 2018 оны төсвийн жилд 80 хувиас, 2019 оны төсвийн жилд 75 хувиас, 2020 оны төсвийн жилд 70 хувиас, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байна.”

3/19 дүгээр зүйлийн 19.5, 19.6 дахь хэсэг:

“19.5.Энэ хуулийн 16.2-т заасан нөхцөлийг 2020 оны төсвийн жилээс өмнө хангана.

19.6.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 онд 5 хувиас, 2016 онд 18.5 хувиас, 2017 онд 9.9 хувиас, 2018 онд 7.5 хувиас, 2019 онд 5.5 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2020 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байлгана.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн дараахь зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.1.22 дахь заалт:

“11.1.22.Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, бүртгэлтэй холбоотой журам батлах.”

2/58 дугаар зүйлийн 58.4.9, 58.4.10 дахь заалт:

“58.4.9.усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;

58.4.10.орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх;”

3/60 дугаар зүйлийн 60.11 дэх хэсэг:

“60.11.Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэг:

“56.2.Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараахь байдлаар төвлөрүүлнэ:

56.2.1.доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн 70 хувийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.

56.2.2.доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн 70 хувийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.”

2/58 дугаар зүйлийн 58.1.8 дахь заалт:

“58.1.8.усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх;

3/58 дугаар зүйлийн 58.1.12 дахь заалт:

“58.1.12.мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;”

4/58 дугаар зүйлийн 58.2.12 дахь заалт:

“58.2.12.мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;”

5/58 дугаар зүйлийн 58.3.4 дэх заалт:

“58.3.4.эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;”

6/58 дугаар зүйлийн 58.4.4 дэх заалт:

“58.4.4.мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх;”

7/59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэг:

“59.2.Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:



59.2.1.энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх;

59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

59.2.3.улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд энэ хуулийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогын шижүүлгийг 60 дугаар зүйлийн 60.6, 60.7-д заасан хувь хэмжээгээр хуваарилах.”

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 58.4.9 дэх заалтын дугаарыг “58.4.11” гэж, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалтын “10 хувь” гэснийг “5 хувь” гэж, 60 дугаар зүйлийн 60.2.6 дахь заалтын “30 хувь” гэснийг “10 хувь” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.7 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.2.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс, бусад зүйл, заалтыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.21 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “урамшуулал”, 15.22 дахь хэсгийн “урамшууллын жишиг” гэснийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “2017” гэснийг “2021” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Хамтын тэтгэврийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийн “36” гэснийг “12” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.10 дахь хэсэг нэмсүгэй.

“12.10.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багтаамж буюу хүүхдийн тоо, хэв шинж, ангиллыг харгалзан багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг боловсролын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”



2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “12 сарын” гэснийг “1-12 хүртэлх сарын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.5 дахь заалтын “зардлын” гэсний дараа “50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалтын “норматив” гэснийг “нормативыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.16 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.2.8 дахь заалтын “Сургалтын төрийн” гэснийг “Боловсролын зээлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “суралцах хугацаанд нь 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн 10 сарын турш, сар бүр үндэсний тэтгэлгийг олгоно.” гэснийг “үндэсний тэтгэлэг олгож болно.” гэж, 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4 дэх хэсгийн “Сургалтын төрийн” гэснийг “Боловсролын зээлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРЭЭДҮЙН ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРЭЭДҮЙН ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 9 дүгээр зүйл нэмсүгэй:



“9 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

9.1.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

**КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Концессын тухай хуульд доор дурдсан агуулгатай зарим хэсэг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:

“7.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 4.1.1, 4.1.3, 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.7-д заасан концессын төрлийн концессын зүйлийн жагсаалтыг батална”

2/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:

“8.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй концессын зүйлийн жагсаалт батлах, концессын гэрээ байгуулах эрх олгох, аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй гэрээ байгуулахыг хориглоно.”

3/9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг:

“9.9.Аймаг, нийслэлийн засаг дарга концессын зүйлийн жагсаалтыг боловсруулан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ зүйлийн 9.6-д заасан зөвшөөрлийг авахаар хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 10.2-т заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаархи энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа, зардал, ашгийн тооцоо болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын



зөвшөөрлийн хамт тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ
ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалтын “12 сарын” гэснийг “1-12 хүртэлх сарын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ
ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“39.2.2.Засгийн газрын үнэт цаасны арилжааны талаархи мэдээлэл, хуваарь;”

2 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн Хоёрдугаар дэд бүлгийн гарчгийг “**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС**” гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “19, 28 дугаар” гэснийг “19 дүгээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсгийн “энэ хуульд” гэснийг “энэ хууль болон Төсвийн тухай хуульд” гэж, 45 дугаар зүйлийн 45.2.1 дэх заалтын “19.8-19.10” гэснийг “19.9, 19.10” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь заалтын “аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах,” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “болон аймаг, нийслэлийн” гэснийг, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “ 19.6,” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь заалт, 28 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 19.3, 19.4, 19.5, 19.6, 19.7, 19.8, 19.13 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.6, 29.7, 29.9 дэх хэсэг, 29.13.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.17 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 31.1.3, 31.2.1, 31.2.3, 31.2.5 дахь заалт, 31.3, 31.4 дэх хэсгийн “аймаг, нийслэл,

дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн” гэсний дараа “асуудал хариуцсан” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4, 29.13 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1.2, 31.2.5 дахь заалтын “сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн” гэсний дараа “асуудал хариуцсан” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “сумын хөдөлмөр эрхлэлтийн” гэсний дараа “асуудал хариуцсан” гэж, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2.2, 31.2.4 дахь заалтын “аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн” гэсний дараа “асуудал хариуцсан” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсгийн “Хөдөлмөрийн төв бирж” гэснийг “хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийн “хөдөлмөрийн төв бирж болон” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “Хөдөлмөрийн төв биржийн даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийн “Хөдөлмөрийн төв бирж” гэснийг тус тус хассугай.

4 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “2016” гэснийг “2021” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтын “12 сарын” гэснийг “1-12 сарын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 47 дугаар зүйл нэмсүгэй:

“**47 дугаар зүйл.** Энэ хуулийн 25.4 дэх хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.



“16.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд суралцагчид олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэгт хамрагдах суралцагчдын тоо, сургалтын төлбөрийн жишиг хэмжээ, сургалтын төлбөрийн зээлийн эргэн төлөлтийг тус тус харгалзан энэ зүйлийн 16.1-д заасан сангийн хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

16.3.Энэ зүйлийн 16.1-д заасан сангийн хөрөнгийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчид олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.”

2 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.13 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.6 дахь заалт, 16 дугаар зүйлийн гарчиг, 16 дугаар зүйлийн 16.1, 16.4 дэх хэсгийн “Сургалтын төрийн” гэснийг “Боловсролын зээлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “сургалтын төрийн” гэснийг “боловсролын зээлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.11, 28.12 дахь хэсэг нэмсүгэй.

“28.11.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлж цагаар тооцож болно. Цалин хөлсийг цагаар тооцох ажлын байрны жагсаалтыг Засгийн газар тогтооно.

28.12.Энэ зүйлийн 28.2 дахь хэсэгт заасан цалингийн нэмэгдлийн дээд хэмжээ нь төрийн албан хаагчийн цалин хөлсний 40 хувиас хэтрэхгүй байна.”

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдон ажиллах болсон” гэсний дараа “, тухайн төрийн байгууллага нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буугдсан, бүтцийн өөрчлөлт орж орон тоо хасагдсан” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.14 дэх хэсгийн “6 сарын” гэснийг “3 сарын” гэж, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “үндсэн цалингийн дунджаас нь ажилласан хугацааг нь үндэслэн тооцож” гэснийг “ажилласан хугацааг нь харгалзан 1-12 сарын үндсэн цалингийн дундажтай тэнцэх хэмжээний” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “тэдний цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг” гэснийг “тэдний цалин хөлсийг” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“3/төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох;”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Төрийн өмчийн улсын хороо” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтын “Төрийн өмчийн хорооны” гэснийг “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 18, 19, 20 дахь хэсгийн “, 17” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 17 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.Засгийн газар, компани энэ хууль болон холбогдох бусад дүрэм, журамд заасны дагуу үнэт цаас гаргана. Засгийн газар үнэт цаас гаргах тохиолдолд Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлнэ.”

2 дугаар зүйл.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.11 дэх хэсгийн “Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас” гэснийг “Засгийн газраас” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн захиргааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ПАТЕНТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Патентийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.14 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.6, 19.8 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “Оюуны өмчийн газарт” гэснийг “оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “Оюуны өмчийн газраас” гэснийг “оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас” гэж, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.4, 9.5, 9.8 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.9, 11.10 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.2, 25.3 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн “Оюуны өмчийн газар” гэснийг “оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 26 дугаар зүйлийн гарчгийн “Оюуны өмчийн газар” гэснийг “Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Оюуны өмчийн газрын” гэснийг “оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Патентийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийн “/цаашид “Оюуны өмчийн газар” гэх/-” гэснийг хассугай.



3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД
ХАМААРАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “Оюуны өмчийн газар” гэснийг “оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 26 дугаар зүйлийн гарчгийн “Оюуны өмчийн газар” гэснийг “Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсгийн “Оюуны өмчийн газартай” гэснийг “оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалтын “Оюуны өмчийн газарт” гэснийг “оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “/цаашид “Оюуны өмчийн газар” гэх/-” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2016 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2015



оны 103 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Энэ тогтоолын 1-д заасан хүүхдийн мөнгийг олгохдоо өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж, хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан нийт өрхийн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрд сар бүр 20 мянган төгрөгийг доор дурдсан нөхцөлөөр олгохыг Монгол Улсын Засгийн газар/Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

2.1.2016 оны 1-6 дугаар саруудад хүүхэд бүрд;

2.2.2016 оны 7-12 дугаар саруудад амьжиргааны түвшний 1-10 дугаар бүлэгт орсон хүүхэд бүрд бэлэн мөнгөөр, үлдэх хүүхдийн мөнгийг хойшлуулан 2019 оноос эхлэн нөхөж олгох.”

2.3.Энэ тогтоолын 2.2-т заасан нөхөж олгох хүүхдийн мөнгийн эх үүсвэрийг тухай бүр Засгийн газрын үнэт цаас гарган бүрдүүлж банканд хадгаламжаар байршуулах.”

2.“Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2016 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2015 оны 103 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “144,000.0 сая төгрөг” гэснийг “223,200.0 сая төгрөг” гэж өөрчилсүгэй.

3.Энэ тогтоолыг Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн өмчлөгчид шилжүүлсэн, шинээр үүссэн орон сууцын ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны өмчлөл болон орон сууцын ипотекийн зээлийг санхүүжүүлэх зориулалтаар Монголбанкнаас банканд олгосон



зээлийн шаардах эрхийн өмчлөл, түүнтэй холбоотой бусад хөрөнгийг Монголбанканд буцаан шилжүүлэхийг Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, өөрийн тайлан тэнцэлдээ бүртгэж авахыг Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолын 2 дугаар заалтад заасан хөрөнгийг цаашид гадаад, дотоодын зах зээлд борлуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Тэрбишдагва/-нд үүрэг болгосугай.

5.Энэ тогтоолыг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн ТӨ-IV Тусгай албан тушаал хэсгийн “Монгол Улсын Ерөнхий прокурор,” гэсний дараа “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн” гэж нэмсүгэй.

2.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн ТӨ-V Тусгай албан тушаал хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн” гэснийг хассугай.

3.Энэ тогтоолыг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай. Үүнд:

1/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:

а/стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх;

б/төмөр зам, авто зам, уул уурхай, эрчим хүчний томоохон төслүүдийг идэвхжүүлэх замаар эдийн засгийн бусад салбарыг дэмжих;

в/уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах, дэд бүтэц, мал аж ахуй, аялал жуулчлал, шинжлэх ухаан болон био технологийн салбаруудад хөрөнгө оруулалтыг татах;

г/татварын бааз суурийг өргөжүүлж, татварт хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх чиглэлээр татварын бүртгэл, хураалт, хяналтын системийн өөрчлөлт, шинэчлэлийг эрчимжүүлэх;

д/газрын төлбөрийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, газрын үнэлгээ, татварын механизмыг сайжруулах ажлыг судалж, эхлүүлэх.

2/Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр:

а/бүх шатны төсвийн захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох;

б/бүтцийн өөрчлөлт хийх болон чиг үүргийн давхардлыг арилгах замаар батлагдсан төсвөөс хэмнэсэн цалингийн сан болон бараа үйлчилгээний бусад зардлыг байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зориулалтаар зарцуулахыг зөвшөөрөх;

в/бараа үйлчилгээний зардлыг дараахь байдлаар бууруулах.

Үүнд:

1/албан ажлын зайлшгүй шаардлага гарч, дээд шатны удирдах байгууллага, албан тушаалтны албан ёсоор зөвшөөрснөөс бусад

тохиолдолд гадаад томилолтын зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх;

2/албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх;

3/тавилга шинээр худалдан авахгүй байх;

4/эмнэлэг, цэцэрлэг, сургуульд зайлшгүй урсгал засвар хийхээс бусад тохиолдолд төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх;

5/төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;

6/төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх;

7/эмнэлгийн түргэн тусламж, онцгой байдал, авлигатай тэмцэх, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, прокурор, цагдаагийн эргүүл хамгаалалт, шүүхийн шинжилгээний алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, хил хамгаалах, батлан хамгаалах салбарын байгууллагаас бусад бүх шатны төсвийн байгууллага албан ажлын хэрэгцээнд нэгээс илүү автомашин хэрэглэхийг зогсоож, тээвэр, шатахуун, сэлбэг хэрэгсэл, үйлчилгээний бусад зардлыг бууруулах;

8/төв, суурин газарт албан ажлын хэрэгцээнд шатахуун бага зарцуулдаг автомашин хэрэглэх, хөдөө орон нутагт ажиллах тохиолдолд албан ажлын автомашин дуудлагаар хэрэглэх журмыг баталж, мөрдүүлэх;

г/улсын төсөв болон Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжүүлж чадаагүй үлдэгдэл, “Барих-шилжүүлэх” концессын гэрээний эргэн төлөлт, шүүхийн шийдвэрээр олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн векселиэр баталгаажуулахгүй байх;

д/төсөвт мөрдөгдөж байгаа норм, норматив, стандартыг шинэчлэн тогтоож, 2017 оны төсвийн жилээс эхлэн мөрдөх;

е/спорт цогцолбор, усан бассейн, соёлын төвийн хөрөнгө оруулалтыг шинээр эхлүүлэхгүй байх, цэцэрлэг, сургуулийг түрээсийн зарчмаар ажиллуулах, төсвийн хөрөнгөөр баригдсан үйл ажиллагаа нь эхлээгүй, дутуу баригдсан барилга, байгууламжийг зарж борлуулах, төсвийн үр ашиггүй хөрөнгө оруулалтыг эхлүүлэхгүй байх.

3/Төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр:

а/хуулиар эрх олгосноос бусад тохиолдолд төсөвт тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэх эрх олгосон болон санхүүжилт хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, бусад этгээдэд аудит, хууль хяналтын байгууллагын холбогдох шийдвэрийн дагуу хариуцлага тооцох;

б/Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газрын хийсэн дүгнэлтэд тусгагдсан зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч, үр дүнг Улсын Их Хурлын 2016 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулах.



2.Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад ажил олгогчоос олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг ажилласан хугацааг нь харгалзан 36 хүртэлх сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээтэй байхаар Төрийн албаны тухай хуулийн 30.2 дахь хэсэгт болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хамт өргөн мэдүүлэх, хэрэгжих хугацааг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн хугацаанаас эхлэн тооцохоор тогтоосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Үндэсний аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 09-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 3,831,706.2 сая /гурван их наяд найман зуун гучин нэгэн тэрбум долоон зуун зургаан сая хоёр зуун мянган / төгрөгөөр баталсугай.

2.Монгол Улсын 2015 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 4,996,886.5 сая /дөрвөн их наяд есөн зуун ерэн зургаан тэрбум найман зуун наян зургаан сая таван зуун мянган/ төгрөгөөр баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 8.25

Индекс: 14003